

**МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК**
Институт истории и
археологии

**МЕЖДУНАРОДНАЯ
АССОЦИАЦИЯ
МОНГОЛОВЕДОВ**

**РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК**
Институт восточных
рукописей



КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: КОЛЛЕКЦИИ РУКОПИСЕЙ И АРХИВНЫХ ДОКУМЕНТОВ

III

**Международная конференция
при поддержке Президента Монголии**



20-22 апреля 2017 г. Санкт-Петербург

Сборник докладов

Санкт-Петербург - Улан-Батор
2019

ННА-72
ДАА-378.121
М-694

Ответственный редактор: Академик С.Чулуун
Редакторы, составители: доктор филол.наук И.В.Кульганек
Ph.D Н.Хишигт
Ph.D Б.Нацагдорж
Ph.D Н.В.Ямпольская
Рецензенты: Ph.D Н.Ганбат
доктор филол.наук Л.Г.Скородумова

Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов. Сборник докладов III международной научной конференции. 20-22 апреля 2017 г. Санкт-Петербург. Россия. СПб.-УБ., 2019 г. -254 с.

Сборник представляет собой собрание докладов III международной научной конференции **“Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов”**, организованной Институтом истории и археологии МАН и Институтом восточных рукописей РАН в г.Санкт-Петербург, 20-22 апреля 2017 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-99978-773-4-5

DOI 10.25882/76vd-bb41

© Институт истории и археологии МАН, 2019 г.
© Институт восточных рукописей РАН, 2019 г.
© Международная Ассоциация монголоведов, 2019 г.

Ж.Саруулбуян

МАРЗАН ШАРАВЫН ШИНЭЭР ОЛДСОН НЭГЭН БҮТЭЭЛИЙН ТУХАЙ

DOI 10.25882/s683-xb82

Марзан Шаравын хос шүүгээн дээр зурсан аж байдлын сэдэвт нэгэн зургийн тухай ярихын өмнө ер монголчууд хүний амьдралыг энгүүнээр уран егөөтэй дэлгэмлээр өгүүлсэн монгол зургийг хэрхэн бүтээж ирснийг дурдалтай. Нүүдэлчдийн амьдралын онцлогоос болж бурхан шүтээн, элдэв зураг урлалаа бүтээх, түүнийг хадгалан нүүдэллэн авч явах өөрсдийн онцгой аргатай байсан. Мэдээж суурьшмал соёлтой ард түмнүүдийн урлаг шиг нэг хананд байнга байлгах, том хэмжээгээр урлалаа бүтээх нь тухайн нүүдэлчдийн хувьд хязгаарлагдмал байсан. Хүрээ хийд, орон суурин газар бол бурханы хөрөг дүр, танка зургуудыг томоор бүтээхдээ хананд нь суурин бүтээхээс татгалзаж голдуу хуйлмал зургууд бүтээж байсан.

XIX-XX зууны эхэн үед гэхэд монгол зураачид эгэл жирийн амьдралыг бодитойгоор өгүүлсэн дэлгэмэл агууламжтай сэдвээр дагнасан зургийг цөөнгүй бүтээж байсан. Энэ нь бурхан шүтээний урлаг, урлалаас онхи ангид хэрнээ тухайн нийгмийн төрх байдал, хүмүний амьдралыг угсаатны зүйн онцлогоор тусгасан аж байдлын уран зургуудыг авдар сав, шүүгээ, галын хаалт, ширээний өр, хаалга үүдний хавтас далавч, орны нүүр толгой, хөлийн татуурга, бурхны торхон, үнэт эдлэл, эрдэнэсээ хадгалдаг модон хайрцаг зэрэгт дугар зайсан, тумбааш, үндэсний наадам цэнгээн, нутаг орны өвөрмөц болоод нийтлэг амьдралыг өгүүлсэн ардын зургуудад ураа гарган үлдээсэн нь элбэг байв. Энэ нь голдуу чинээлэг ноёд дээдэс ихэс лам нарын урлагийн мэдрэмж тааллаар дамжин зураачдад захиалга өгч зуруулж байсан байна.

Тухайлбал Сэцэнхан аймгийн Бишрэлт засгийн хошууны ноён хүлэгч, зураач М.Пүрэвжав⁴⁹ нь авдар сав, шүүгээ, галын хаалт, орны нүүрэн дээр ардын цэнгэл баяр наадам, хурдан морины уралдаан, бөхийн барилдаан, ан ав, байгалийн үзэмж зэргийг уран яруугаар зурсан нь хожмын үед уламжлан хадгалагдаж үлдсэн юм.

⁴⁹ Ж.Саруулбуян. «Сэцэн ханы хүлэг». УБ. 1997

Иймэрхүү аж байдлын сэдвийг дэлгэмлээр монгол зургийн аргаар Марзан Шаравын зурсан гэх тодотголтой нүүрэн талаасаа онгойдод доод талдаа хос шургуулгатай бурханы хос шүүгээний зургийн талаар өөрийн саналыг толилуулж байна.

Энэхүү ховор чухаг зурагт хос шүүгээг (хэмжээ нь: өндөр 56, өргөн 29, урт 46, гар, модон хийцтэй) 1983 оны 2 дугаар сарын 18-нд (П-5, Т-103) хөмрөгт Сүхбаатарын районы 20 дугаар хорооны Яргайтын 54-ийн 27 тоотод суудаг Ээсүрэнгийн Өлзийжаргал тэр үеийн Хувьсгалын музейд худалджээ.

Энэхүү Марзан Шаравын зурсан зурагтай хос шүүгээг Сэцэнхан аймгийн Боржигин Сэцэн вангийн хошууны Цэен бэйс гэгч хүн эдэлж явсан аж. Цэен бэйс VIII богд Жавзундамбын дэргэдийн шадар хүн байсан бөгөөд тэрбээр Марзан Шарав гэгч зураачийг гэртээ урьж хос шүүгээний нүүр шургуулга, бүхий л талбайд нутаг орныхоо амьдрал, сүм дуган, адуу малаа бүгдийг багтаан зуруулсан гэдэг гэж өвөг дээдсээсээ дам сонссоноо Өлзийжаргал тодорхойлон бичжээ. Зуруулсан оныг 1912 он гэж бичжээ.

Шинэ үсгээр бичсэн тодорхойлолтын дор монгол бичгээр татлан бичсэн нь:

«Өлзийжаргалын ээжийн дүү Даваанасан гэдэг хүний ээж (Гэндэн) хүүхдээн тэтгэхээр өргүүлсэн. Чингэтэл тэр хүүхдийг мөн Цэен бэйст өргүүлснээр Цэен бэйсийн хүү болж байгаад түүний (Цэен бэйсийн) юмыг авах болжээ.

Марзан Шаравын хос модон шүүгээн дээр зурсан зургийг үүнийг бичигч мөнөөх алдарт «Монголын нэгэн өдөр» зурагтай шууд холбож, түүнтэй харгалдуулан харьцуулах үндсэн зорилго тавиагүй, дам бусаараа эрхбиш суурь үндэс нэгтэй гэж үзэж байна. Энэхүү бүтээлийг бичигч модон шүүгээн дээрх зургийг «Хошууны нэг өдрийн амьдрал» гэж нэрлэе.

Хос шүүгээний нүүрт хошууны төв буюу хэрэм хашаа бүхий хийд, том гэр дуган, хошууны тамгын газар улаан хөлтрөгт гэр, туг хиур байгаагаас нь эхэлнэ. Нүүдэлчдийн мал аж ахуйгаа эрхлэх өдөр тутмын амьдралын хэв хэвшил энд тусгагдсан, өөрөөр хэлбэл «Монголын нэг өдөр», «Үрс гарч байна» дэлгэмэл туульсын бүтээлийн өгүүлэмж дүр дүрсэлгээ, үйл явдлуудтай нэлээд давтагдмал өгүүлэмжтэй хэрнээ өвөрмөц онцлог ялгамжтай. Монгол нутгийн нэгэн хошууны уул ус байгалийн ерөнхий үзэмжээс эхлээд

овоо тахилга, ан гөрөө, эргэл мөргөл, бадарчин яваачингаас эхлээд, адуун дээрээ морь уургалж байгаа адууч эрс, худаг дээр ус аваад малаа услаж байгаа малчин, жинчид, майхнаа бариад буучихсан, тэмээний ачаа хомыг буулгаж амраан байгаа, гэрийн гадаа тэрэгний дэргэд хөөрөглөн суугаа хоёр хүн, хонио сааж байгаа эхнэр, эмээлтэй морио алдчихаад барих гэж сандарч байгаа хүмүүс, лам багшдаа мөргөж байгаа ламхай, хошуу тамгын үүдэнд байгаа мухлаг тэрэг, морины уяа, уулзаагүй удсан хоёр золгож байгаа, тэртээ байгаа хот айл руу хавчиг үүрэгтэй нэгэн бадарч очиж яваа, хээр хөдөөд жодгороо босгон даян хийж суугаа лам, алсад тэмээн жин явж байгаа түүнийг тосон морьтон, явган тэргэнд багавтар юм тавин түрж яваа хиа, сүмийн үүдэнд сунан мөргөж байгаа мөргөлчид бүгд дүрслэгджээ.

Хос шүүгээний наашаа онгойдог нүүрэн талын хоёр том таглаан дээр иймэрхүү байдлаар зураад доод талын зэрэгцээ хоёр шургуулгын нүүрт нэлээд томруунаар улаа нэхэж яваа улаачийн, ачлагатай морь нь чангаагаад явахгүй сандраад байгаа, тэмээчин тэмээн дээрээ яваа байдал, нэгэн эхнэр хувингаа барьчихсан зарцтайгаа хамт хонио саахаар ирж байгаа, үнээн зэлэн дээр үнээгээ саахаар тоорцогтой залуу бүсгүй байгаа, бух үнээ рүү нь ирж үймүүлж хаа хөж болж байгааг дүрсэлжээ. Мөн хос шүүгээний тавцан дээд талд өнгийн дагнаасаар алхан хээ урлан зураад голд нь эвэр угалзан дотор могой, мэлхий, хавч, цох, эрвээхэй, хилэнцэт хорхой, дун зэрэг амьтны дүрст угалз хээтэй уялдуулан зохиомжлон хоёр өөр зохиомжоор ихэд нямбайлан зуржээ.

Хос шүүгээний нүүр тавцанд урласан «Хошууны нэг өдөр» гэж нэрлэж байгаа энэхүү зургийн сүм дуган, гэр бараа, тэрэг түрэг, адуу тэмээ, үхэр, хонь ямаа, хүмүүсийн хөдөлгөөн дүр донж байдлыг Марзан Шаравын зурсан гэгддэг «Монголын нэг өдөр» «Үрс гарч байна» дэлгэмэл том бүтээлтэй ерөнхий өгүүлэмж ур чадвараараа ойртон дүйж байна. Ялангуяа малын дүрсэлгээ, зураас хэм хэмнэлийн ерөнхий байдлаараа нийлж байгаа бөгөөд ямар нэгэн дэлгэмэл том бүтээл бүтээх сурвалж судалгааны анхны эх загвар туршилтын хэмжээнд зурагдсан байж ч болохоор. Түүнчлэн гэр бараа, мухлаг тэрэг, майхан, жодгорыг зурсан байдал, мөнөөх нэр бүхий том бүтээлд дүрслэгдсэн дүрс ав адилхан байна. Морь малын элдэв хөдөлгөөн, давхиж яваа байдал ч мөн адил бөгөөд Монголын нэг

өдрийн «морьдын төрхтэй адил хирнээ, морины дэл сүүл, тэмээний зогдор үс зэргийг тийм ч сайн уртайгаар зурсангүй, үхэр хонины дүр дүрсэлгээ ч мөн том бүтээлтэй ихээхэн төслөг зарим малын хөдөлгөөнүүд давхцмал мэт санагдана. Хэдийгээр хос шүүгээн дээр зурсан бүтээлийг «Монголын нэг өдөр» бүтээлтэй өнгөц харьцуулах маягаар үзэхэд нэг хүний зураг мэт санагдавч «Монголын нэг өдрийн» дүр дүрсэлгээ, хэв донж, ур чадал өөр өөр арга барил харагдаж байгаа бөгөөд зургийн гүйцэтгэл татлаганаас нь «Хошууны нэг өдөр» модон дээрх зургийг Марзан Шарав зурсан. «Монголын нэг өдөр»-ийг олон зураач нийлж зурсан баймаар сэтгэгдэл төрнө, нэг хүний гараар бүтээгдсэн гэхэд эргэлзээ төрнө.

Энэ дашрам өгүүлэхэд судлаачид «Монголын нэг өдөр», «Үрс гарч байна» бүтээлийг М.Шарав ганцаараа зураагүй олон зураачид нийлж бүтээсэн юм, харин Марзан Шарав идэвхтэй оролцсон гэж бичиж тэмдэглэсэн нь цөөнгүй. Үүнийг ихэнх судлаачид эсэргүүцдэг. Судалгааг тус тусдаа хийгээд гүйцэтгэлийг хамгийн сайн уртай зураачид нэгэн загварт багтаан бүтээсэн нь ойлгомжтой.

«Хуучин Нийслэл хүрээ, Гандан сүм дуган, Наймаа хот, Манзширийн хийд, Богд хааны гол орднуудыг багтаасан ба Да хүрээнд цам гарч байгаа буюу Майдар эргэж байгаа зэрэг Монгол дахь шашны бүх үзэгдлүүд нь бүгд нэг өдөр болж байгаа байдлаар харуулсан том зураг зурсан бөгөөд мөн зун цагт цагаан идээ дэлгэрч, гүү барихыг «Үрс гарч байна» гэдэг нэг том зурагт үзүүлжээ. Энэ хоёр том зургийг хийхдээ Шарав нь зураач нөхөд, Сампил, Данзан, Жүгдэр нарын зэрэг зураачидтай хамтран зуржээ⁵⁰ гэж тэмдэглэжээ. Ингэж барим тавим бичиж хэлсэн Дамдинсүрэн зураач бол Шаравтай хамт Хэвлэлийн хороонд ажиллаж байсан түүнийг хамгийн сайн мэдэх, бүтээлийнх нь тухай үнэнээр өгүүлсэн цөөн хүмүүсийн нэг юм.

«Бизьяагийн аймгийн алдарт зураач Шарав, Их хүрээний олон зураач нартай хамтарч зураг хийлцэхдээ «Нэг өдрийн явдал» гэдэг томхон хоёр зургийг идэвхтэй зохион зурж оролцсон. Б.Шаравын уран бүтээлд Богд хааны Хайстай лаврин сүм ордны гар зургийг хольж нөхсөн нь ташаарч илүүдсэн байх. Урьд Их Хүрээний зураач

⁵⁰ Д.Дамдинсүрэн. Зураач Марзан Шарав//Бурхач, уран зураач Д.Дамдинсүрэнгийн амьдрал, туурвил судлал». (Эрхэлсэн Ж.Саруулбуян, Г.Даариймаа)/ УБ. 2012, хуудас 39

нар амьдралыг уран хошин дүрсэлж зурдаг онцлогтой байсан бөгөөд үүнээс хуваалцаж эзэмшвэл зохих наад зах нь гуч гаруй зураачид байх ёстой»⁵¹ гэжээ.

«Сүүлийн үед Марзан Шарав их л нэрд гарчихснаас биш үнэндээ том уран бүтээлч биш байсан болов уу гэж боддог. «Монголын нэг өдөр»-ийг түүний нэртэй холбож ярих юм. Би хувьдаа Шарав гуайн бүтээл гэхэд сайн итгэдэггүй гэж⁵² урлаг судлаач доктор, ардын зураач Н.Цүлтэмийн хэлсэн нь бий. «Олноо өргөгдсөний хоёрдугаар оноос Хүрээний зураач нар Богд хааны зарлигаар буюу Их Хүрээний сав газар, түүний ойр орчимд байгаа тэр үеийн нийгэм, амьдралын олон талын үйл явдлуудыг тусган харуулсан сайхан цуврал зургуудыг том жижиг хэлбэрээр зурсан байдаг байв. Тэрхүү зургуудыг бүтээхэд нэрт зураач нар тэргүүлж удирдаж зохион байгуулалттай ажиллаж байсан байна. Тухайлбал:

Тойсүмлин аймгийн нэрт зураач Цэнд баруун урд хэсгийг, Зоогой аймгийн алдарт зураач Данжин баруун хойд хэсгийг, Зоогой аймгийн алдарт зураач Жүгдэр зүүн хойд хэсгийг, Сүнгийн аймгийн нэрт зураач Цэдэнжав зүүн урд хэсгийг тус тус төлөвлөн авч удирдан зааварлан тийнхүү дөрвөн чиглэлд бүх зураачдыг зохион байгуулж, тэд их хүрээнээс гадагш хоёр өртөө (60 км-т) багтсан хөдөө орон нутгийн байдал, мал аж ахуй, газар тариалан, өвс хадлан, ан гөрөө, найр хурим, уул овоо, ус зам, дуган сүм хийд, хүрээ, хар борчуудын хороолол, гадаадын орос, хятад оршин суугчдын байрлал зэргийг хуваарилан авч зурахаар төлөвлөсөн газруудаар явж, гудамж талбай, хашаа байшин, айл гэр, хүн мал, худаг ус, ан амьтад тэргүүтэн замдаа тохиолдсон бүгдийг ажиглаж харж тэмдэглэн зурах үүрэгтэй судалгаа хийж ирсэн юм гэнэ⁵³.

Д.Дамдинсүрэн зураачийн өгүүлэн бичсэнийг «Марзан Шаравын туурвил зүй» хэмээх томоохон бүтээл хийсэн урлаг судлаач доктор Л.Батчулуун шууд үггүйсгэж аман яриа төдий зүйл гэж үзжээ⁵⁴.

⁵¹ Д.Дамдинсүрэн. Их Хүрээний нэрт урчууд. (Эрхэлсэн Ж.Саруулбуян, Г.Даариймаа) УБ. 2012, хуудас 141-142

⁵² Г.Нямаа. Цүлтэм гуай «Монголын нэг өдөр»-ийг Марзан Шаравынх гэдэгт итгэдэггүй (Зууны мэдээ. 1999 №38)

⁵³ Д.Дамдинсүрэн «Их Хүрээний нэрт урчууд» (Эрхэлсэн Ж.Саруулбуян, Г.Даариймаа) УБ. 2012, хуудас 130-131

⁵⁴ Л.Батчулуун. «Марзан Шаравын туурвил зүй» (Ариутган шүүсэн А.Цанжид) УБ.

Энэ нь их Шарав зураач бүхнийг л ганцаар бүтээсэн түүнтэй хэн ч зэрэгцэн очиж чадахгүй гэх өрөөсгөл хандлагатай судалгааны нэг жишээ болно.

Марзан Шаравын гэх энэхүү шинээр олдсон бүтээлийн тухай цухас ярихдаа нэгэнт орчин үеийн дүрслэх урлагийн түүхэнд нэрээ гүн бат үлдээсэн их зураачийн нэр бүхий бүтээлүүдийн тухай тодорхой баримттай сурвалжийг хойч үе дахин нягтлан үзэж судлахыг давхар сануулан буй нь энэ юм. Ер Монгол оронд ардын хувьсгал ялан мандахын зэргэмж хувьсгалын дууч зураачаар хэнийг хэрхэн яаж тодруулах вэ гэдэг үйлс төрийн удирдагчид, шинэ сэхээтнүүдийн дунд хүчтэй яригдаж, Ленинийг анх удаа Ази тивд зурснаараа Шаравыг тодруулж, олон урчууд бүгдээр нийлж хийсэн болоод, Шаравын огтоос оролцоогүй бүтээл, зураагүй зургийг хүртэл түүний нэр дээр тохож, урлагийн түүхэндээ сайхнаар дуурсган бичсэн нь зарим нэг талдаа эндүүтэй явдал болсон нь гарцаагүй юм.

Марзан Шарав бол өөрөө ихээхэн хувьсгалч, хуучин феодалын нийгмийг хурц шүүмжилдэг хүн байсан төдийгүй, шинэ цагийн өнгөнд ихэд хурднаа зохицсоноороо бусад хуучин зураачдаас онцгойрон гарч ирсэн нь дамжиггүй.

Марзан Шарав, ардын намын зураач хэмээгдсэн Пунцагжунай, зураач Сампил, Сангийн Жүгдэр, Сампилов, Николай Рерих, К.Померанцев болоод бас бус зураачидтай танил байсан байна⁵⁵.

«Марзан Шаравынхаар Зөвлөлтийн мэргэжилтэн зураач Померанцев их л орж гарамхай байжээ. Померанцевын уран бүтээл дэх монгол сэтгэлгээт хийсвэрлэсэн уран зургуудыг өнөөдөр үзэхэд Шаравын уран бүтээлийн нөлөө эрхгүй тусгалаа олжээ гэх сэтгэгдэл төрнө⁵⁶.

Марзан Шарав 1931 онд ЗХУ-д хоёр сарын хугацаагаар явж Зөвлөлт орны хөгжил ба урлагийн байдалтай танилцжээ. Энэ нь түүний сүүл үеийн бүтээлүүдэд тусгалаа олсон байдаг.

«Марзан Шарав бол Монголын үндэсний чимэг чимэглэх урлаг болох хээ угалзны хэм хэмнэл өнгийн дагнаас зохицол, бэлгэдлийг

2009, хуудас 136-137

⁵⁵ Л.Гаваа «Мартагдашгүй үйлстэн» («Соёл урлаг» сэтгүүл 1989. №3)

⁵⁶ Ж.Саруулбуян. Марзан Шаравын мэндэлсний 120 жилийн ойд зориулсан өгүүллийн гар бичмэл

чадварлаг ашиглан бүтээдэг байсан⁵⁷ нь олон бүтээлд нь илэрдэг.

«Хошууны нэг өдөр» хэмээн нэрлэж байгаа бүтээлийн хос шүүгээний тавцанд зурсан өнгийн дагнааст алхан хээн дунд лусын амьтад болох могой, мэлхий, хавч хорхой тэргүүтнийг амьдчилан зурсан нь мөнөөх захиалагч эзэн Цэен бэйсийн өгөгдлөөс гадна өөрийнх нь зурах дуртай хээ угалз, амьтан ургамлыг амьдчилан зурах сонирхолтой холбоотой байсан мэт санагдана. «Үрс гарч байгаа нь» зурагт наадмын асрын зүүн баруун хоёр талд босгосон том эрээн майхны хээ угалз дүрсэлгээнд мөнөөх хавч хорхой, лус дэлхийн амьтдыг амьтан дүрст хээ угалз руу оруулан дүрсэлсэн нь үүнийг гэрчилнэ. Энэ нь тухайн үед лус дэлхийгээ баястан аргадах, түүний эздийг төлөөлүүлэн дүрслэх нь элбэг байжээ.

Марзан Шарав, би тийм бүтээл хийсэн энээ тэрээ гэж нэг их ярьдаггүй, ялангуяа ардын хувьсгалаас өмнө зурсан, бүтээлцсэн бүтээлүүдийнхээ тухай өөрөө товтой ярьдаггүй, ярихыг ч хүсдэггүй байсныг тэр цагт хамт амьдарч байсан олон хүмүүсийн дурсамжид өгүүлсэн нь бий.

Эрдэмтэн зохиолч Ц.Дамдинсүрэн, би Марзан Шаравтай танил номын зургаа зуруулж явсан хүн. Түүний бүтээлүүдийг ч их анхаарч, элдэв мадаг мапаанаас жинхэнэ бүтээлийг нь хамгаалан хэлж өгч байсан хүн.

«Ц.Дамдинсүрэн соёлын өвийг сүйтгэж байсан аюултай цагт алдар суут уран бүтээлч Занабазарын сонгодог гарамгай бүтээлүүдийг олон сайхан бурхны хамт авран гаргасан шигээ мөн архивт дарагдмал байсан зураач Б.Шаравын хоёр хөрөг зургийг олж тодруулан өгснөөр үзмэрийг гэрэл гэгээнд гаргажээ⁵⁸.

Энэхүү илтгэлд өгүүлэн буй Марзан Шаравын зурсан гэх хос шүүгээн дээрх дэлгэмэл зураг нь Марзан Шаравын жинхэнэ гарын урлал байх магадлалтай юм гэж зохиогч үзэж байна. Энэхүү бүтээлийн зурлага татлага, ур дүрсэлгээг «Монголын нэг өдөр», «Үрс гарч байгаа нь» гэх дэлгэмэл томоохон бүтээлүүдтэй шууд тулган харьцуулах нь учир дутагдалтай, яагаад гэвэл нэг зураачийн бүтээлийг холбож бүтээлтэй харьцуулах нь нэгэн талын хүчлэн

⁵⁷ И.Ломакина «Марзан Шарав» Москва 1974, стр 45-47

⁵⁸ Р.Отгонбаатар. «Зураач Марзан хэмээх Б.Шаравын тухай зохиолч эрдэмтэн Ц.Дамдинсүрэн анхаарч байсан нь» (Дүрслэх урлаг, уран барилга» 1990 № 1)

онолдуулах арга болно. Тэрхүү томоохон бүтээлүүд өнөөдөр гагц Марзан Шаравын нэрээр алдаршсан бөгөөд хойчийн судлалд Марзан Шарав нарын бүтээл хэмээн үзэж анхааран судлууштай санагдана.

«Марзан Шар (Шарав) бол дуртай хүндээ юу ч хамаагүй зураад өгнө. Дургүй хүнд ер зурж өгдөггүй юм гэдэг. Богд, Марзан Шарыг урьж зураг зуруулах гэхэд зургаа гүйцээлгүй хаячихаад явчихсан байсан гэдэг. Бизьяагийн ламын нас барснаас хойш Балдан хачингийн гэр бариулаад сууж байсан»⁵⁹. Марзан Шарав гэрлэж бараалсангүй зөвхөн өөрийн зураг урлал бүтээхийн их авьяастаа дулдуйдаж Богд хаан болоод Богдын дэргэдийн ихэс лам нарын дэргэд тусгайлан өргөөлөн сууж бурхан болоод элдэв зүйл зурж өгч байсны нэгэн нь Богдтой шадар ойр байсан Цэен бэйсийн хүсэлтийг хүлээн авч гэрт нь сууж хос шүүгээн дээр «Хошууны нэг өдөр» зураг зурж өгсөн нь үнэн магадад дөхүү ойр болтой.



Хос шүүгээ. Марзан Шаравын зураг

⁵⁹ Өвгөн Жамбалын яриа (Хууч яриаг тэмдэглэсэн Ц.Дамдинсүрэн). // Цэндийн Дамдинсүрэн. Бүрэн зохиол. Дэд боть, тайлбар сэлт, ном зүй үйлдэж хэвлэлд бэлтгэсэн Д.Цэдэв. УБ 2012, хуудас 194



*Хос шүүгээний нүүрэн тал.
Нааш онгойдог таган дээрх зураг 1*



*Хос шүүгээний нүүрэн тал.
Нааш онгойдог таган дээрх зураг 2*



Хос шүүгээний нүүрэн талын доодох шургуулган дээрх зураг



*Хос шүүгээний тавцан дээрх зураг.
Лусын амьтад, хээ угалз*